

юм бол үр дүнтэй шийдвэр гаргаж, үйл ажиллагааны бүтээмж, үр дүнг сайжруулах болно гэж дүгнэж байна.

Б. Ундарбат - Хууль сахиулахын удирдлагын акадагийн
821 дүгээр дамжааны суралцагч, хошууч

ХИЛ ХАМГААЛАЛТЫН АР ТАЛ ХАНГАЛТЫН ОНОЛЫН ҮНДЭС, АР ТАЛ ХАНГАЛТЫН УДИРДЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хураангуй. Хилийн цэргийн ар тал хангалтын удирдлага нь ХХЕГ-ын дарга-хилийн отряд- хилийн застав- хилийн харуул- хилийн манааны ахлагч гэсэн удирдлагын босоо байрлалтайн дээр бүхий л зэрэг албан тушаалын дарга, захирагч нарын үүрэг эрх мэдэл, хариуцлага нь холбогдох хууль дүрэм, журам, заавраар нарийн зохицуулагдан тогтоосон хяналтын иж бүрэн механизм юм гэдгийг харуулахыг зорилоо

Түлхүүр үг. Цэргийн ар тал, тавигдах шаардлага

Ар талын алба гэдэг ойлголт нь: Өөрийн ангийн тавигдсан зорилгыг ханган биелүүлэх замаар бие бүрэлдэхүүн анги, салбарыг мэргэжлийн дагуу материал техник хэрэгсэл болон тэдний нийгэм соёлын хэрэгцээг ханган үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй удирдлагын болон орон тооны мэргэшсэн хүч хэрэгсэл бүхий нэгж юм.

Ар тал хангалт нь: Хилийн анги \отряд\ застав \салбар\ -ын Улсын хил хамгаалах үндсэн үүргийг биелүүлэх, цаг ямагт байнга бэлэн байх, бэлэн байдлыг хангах, Хилийн цагийн байдлаас үндэслэн шинээр тавигдсан үүрэг даалгаврыг биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ар талын албадын чиглэлээр хэрэгжүүлж буй цогцолбор арга хэмжээ юм.

Хилчид бид шинжлэх ухаан ба онолын гүнзгий мэдлэгт тулгуурлан улсын хил хамгаалалт, түүний онолын үндсэн асуудлуудыг судлах нь зайлшгүй шаардлагатай албаны хэрэгцээ мөн.

Харин онол гэдэгт¹ бодит юмс үзэгдлийн хэлхээ, холбооны зүй тогтлын тухай цогц ойлголтыг багтаасан мэдлэгийн аль нэг салбарын үндсэн санаа, шинжлэх ухаанч мэдлэгийн хэлбэр орно.

Онол нь ямар нэгэн тогтвортой хүчин зүйлийн нөлөөллийг олон жилээр хуримтлуулан нэгтгэж, тэдгээрт явуулсан туршилтад дүн шинжилгээ хийн, үйл ажиллагааны явцад нэмж тодотгосноор бий болдгийг бид мэдэх билээ. Онол бүрэлдэх энэхүү үе шатанд судалж буй зүйл, үзэгдэл,

¹ Ш.Арвай, А.Муратхан. Улсын хил судлал: Онол практикийн зарим асуудал. - УБ., 2016

үйл явц болон тэдгээрийн хоорондын хамаарлын талаар хэмжилт, хяналт хийсэн тайлбарууд ихээхэн зонхилдог учиртай.

Судалгаа, шинжилгээний ажил гүнзгийрэх тусам онолын агуулгад үзэгдэл, үйл явцын хоорондын шинж чанар, тэдгээрийн шалтгаан, холбоо улам бүр нээлттэй болж ирдэг. Ийм байдлаар бий болсон онол нь судалж буй объектын хөгжлийн явцын хууль, таамаглалыг бүрэн үндэслэлтэй гаргахад дөхөмтэй болно.

Аливаа онол нь судалгааны объект, судлах зүйлтэй, категори буюу ерөнхий ойлголттой, өөрийн гэсэн хууль ба зүй тогтолтой, үндсэн зарчимтай байж бие даасан онол болдог.

Хил хамгаалалтын ар тал, хангалтын онол нь хил хамгаалах байгууллагын бүтцэд хангалт, үйлчилгээний нэгжүүд бий болсонтой холбоотой юм.

Ар тал нь Хилийн цэргийн бүх талын хангалтад чухал байр суурь эзэлдэг бөгөөд өөрийнхөө үйл ажиллагаагаар хил хамгаалах үүргийг амжилттай биелүүлэхэд нөлөөлдөг.

Тайван (ердийн) болон дайны (хилийн цагийн байдал хүндэрсэн) үед хил хамгаалалтыг явуулж буй Хилийн цэргийг материал техникээр хангах боломжтой хувилбарууд болон тэдгээрийн өөрчлөлтийг урьдчилан харах нь энэхүү онолын судалгааны зорилго мөн бөгөөд тэр нь ар талын төрөл бүрийн хангалтын агуулга, хэмжээг тодорхойлох, байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх, түүнд бэлтгэх үеийн янз бүрийн нөхцөл байдалд ар талыг удирдах хувилбаруудыг тооцоолох боломж олгодог.

Уг онол нь улсын хил хамгаалалт болон алба-байлдааны онцлог нөхцөл байдлын үед тохирсан хилийн цэргийн ажиллагаа, түүнд бэлтгэх үеийн оператив болон цэргийн ар талын хангалтуудыг урьдчилан тооцох нөхцлийг бүрдүүлнэ. Үүн дээр тулгуурлан улсын хилийн хэсэгт тэдгээрийн гүйцэтгэх үүргийн агуулга, хэмжээ, тайван болон дайны цагт үүрэг гүйцэтгэхэд шаардагдах хүч хэрэгсэл, ар тал болон түүнийг удирдах нэгжид тавигдах шаардлагыг тодорхойлж, үндэслэлийг гаргадаг байна.

Ар тал хангалтын онол нь ар талыг бүх талаар бэлтгэх арга хэмжээний боловсруулалт, үндэслэл, улсын хил хамгаалалтын алба-байлдааны ажиллагааг хангахад шаардлагатай ар талыг байгуулах болон түүний бүх талын бэлтгэлтэй байх үндэслэлийг боловсруулах асуудлуудыг авч үздэг бөгөөд энэ нь оператив, цэргийн ар тал болон тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг болох анги, салбаруудын материал хангалт, нэгжүүдийн зохион байгуулалтын бүтэц, тоо хэмжээ, боломжийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Хил хамгаалалтын ар тал хангалтын онол нь анги, салбаруудын ар тал болон тэдгээрийг удирдах нэгжийг байршуулах орчин үеийн техник хэрэгслээр хангах. шилжүүлэн байрлуулах тухай шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, ар талыг удирдах байгууллага, салбарын ар талын бие бүрэлдэхүүнд онолын мэдлэг олгох, ар талыг удирдах. төрөл бүрийн зориулалттай ар талын салбаруудын тусгай үүрэг гүйцэтгэхэд шаардагдах практик чадварыг олгоход чиглэсэн аргачлал, зөвлөмжийг боловсруулах. хилийн цэрэгт хэмнэлтэт, оператив цэргийн хэрэгслийн нөөцийг тогтоох, тэдгээрийг хил хамгаалах чиглэл, хэсэгт байрлуулах. цуваажилт. нөөцлөх, хадгалах, ар талыг хамгаалах талаар зөвлөмж боловсруулахад нэн шаардалгатай онолын үндсийг бий болгоно.

Түүнчлэн шинэ газар оронд ар талын анги, салбарыг шилжүүлэн байрлуулах. материаллаг хэрэгслийн нөөцийг бий болгох, тэдгээрийн зарцуулалт, хохирлыг тооцох онолын үндэстэй дүрэм, журам, зөвлөмж, хэм хэмжээг боловсруулахад энэхүү онолын арга, аргазүйг ашиглана.

Ар тал хангалтын онолын нэг зангилаа асуудал бол хилийн цэргийн ар талын орон тоо, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оршино. Үүний тулд ар талыг удирдах үйл ажиллагааг хөгжүүлэх, ар талын удирдлагын үр ашигтай бүтэц зохион байгуулалт, түүний ажиллагааны аргачлалыг боловсруулахад онцгой анхаарах хэрэгтэй. Мөн удирдах үйл ажиллагааг автоматжуулах, ар талын удирдах байгууллагууд, төрөл, нэгжүүдийн хооронд болон удирдлагын бусад нэгж, орон нутгийн засаг захиргааны хооронд харилцан ажиллагааг зохион байгуулах нь ихээхэн ач холбогдолтой.

Энэ бүхэн хил хамгаалалтын ар тал хангалтын онолын судлах зүйл, түүний агуулгыг тодорхойлдог байна

Ар талын хангалт нь дотороо. материалын, хүн эмнэлгийн, мал эмнэлгийн, орон сууц ашиглалтын, худалдаа ахуй үйлчилгээний, санхүүгийн, инженер-техникийн гэж ангилагдана.

Хилийн цэргийн нэгтгэл, ангиуд нь ар талын хангалтыг зохион байгуулах үүрэг бүхий ар талын анги, салбаруудтай байдаг.

Онцгой нөхцөл байдлын үед хилийн отрядын ар талын удирдлагыг зохион байгуулах онцлог.

Ар талын удирдлага нь цэргийн удирдлагын бүрэлдэхүүн хэсэг мөн.

Ар талын удирдлага гэж захирагч, штаб, ар талын дарга, ар талын албадын дарга нар бусад албан тушаалтнуудын нэгдсэн нэг зорилго чиглэлтэй үйл ажиллагааг хэлэх бөгөөд онцгой нөхцөл байдал үүссэн үед үүрэг гүйцэтгэж байгаа нэгтгэл, анги, салбаруудын ар талын хангалтыг

зохион байгуулах. ар талын бэлэн байдлыг хангах зорилгоор зохион байгуулагдана.

Ар талын удирдлагад дараах арга хэмжээ хамаарагдана. Үүнд:

- Хилийн отрядын ар тал, техникийн хангалтыг зохион байгуулах шийдвэрээ гаргана.
- Захирагдагсаддаа үүрэг хүргэнэ.
- Хилийн отряд, түүний салбаруудын хил хамгаалалт, байлдааны ажиллагааны ар талын хангалтыг төлөвлөнө.
- Зэргэлдээ нэгтгэл, ангиудын ар талын албад, ар талын анги, салбаруудтай харилцан ажиллагааг зохион байгуулна.
- Хилийн отрядын байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбогдолтой ар талын хангалтын чиглэлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- Ар талын удирдлагын системийг зохион байгуулна.
- Онцгой нөхцөл байдал үүссэн үед хилийн отрядын ар талын хангалтыг зохион байгуулах бэлтгэлийг хангана.

Ар талын найдвартай удирдлагыг хангахын тулд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Ар талын дарга, албадын дарга нар, ар талын салбаруудын захирагч нар аливаа ажлыг зохион байгуулах ур чадварыг эзэмшиж, мэрэгжлийн өндөр түвшинд хүрсэн байх.
- Орчин үеийн хил хамгаалах болон байлдааны ажиллагааны шинж чанар, түүнийг явуулах арга ажиллагааг гүн гүнзгий ойлгон суралцсан байх.
- Өөртөө захирагдсан ар талын анги, салбаруудын бололцоо, хүчин чадлыг байлдааны ажиллагааны явцад бүрэн дүүрэн ашиглах чадварыг эзэмшсэн байх.
- Хүлээн авсан үүргээ судлаж, цагийн байдлыг үнэлэх чадварыг эзэмшсэн байх.
- Ар талын хангалтыг төлөвлөх, захирагдагсаддаа үүрэг тавих, шийдвэрээ гаргах ажиллагааг шуурхай зохион байгуулах чадварыг эзэмшсэн байх.
- Аливаа ажлыг гүйцэтгэх өндөр чадвар, сахилга батыг эзэмшсэн байх.

Ар талын удирдлага, ар талын хангалтыг зохион байгуулах албан тушаалтнуудын үүргүүд.

Захирагч. Өөрөө биечлэн буюу штабаараа, орлогч нараараа, өөрт шууд захирагддаг албадын дарга нараараа дамжуулан отрядын ажиллагааг удирдана.

Хилийн отрядын штаб. Байлдааны ажиллагааны бүх талын хангалтыг зохион байгуулна. Хилийн отрядын даргын өгсөн үүрэг, захирамж, зааварчлагааг болон ар талын хангалтыг зохион байгуулах, төлөвлөхтэй холбогдолтой өгөгдөхүүнийг орлогч нарт шуурхай хүргэнэ.

Цагийн байдлын өөрчлөлтийг тухай бүр мэдээлэх, хилийн отрядын даргын захирамжаар харуул хамгаалалтанд нэмэгдэл хүч хэрэгслүүдийг гаргаж үүрэг гүйцэтгүүлнэ.

Ар талын дарга. Байлдааны болон ар талын цагийн байдал, заставуудын гүйцэтгэж байгаа үүргийг байнга мэдэж, ар талын хангалтыг зохион байгуулах саналаа хилийн отрядын даргад илтгэхэд бэлэн байна.

Ар талын дарга хилийн отрядын даргын гаргасан шийдвэр, өгсөн зааварчлагааны дагуу өөртөө захирагдсан албадын дарга, ар талын салбаруудын захирагч нарт үүрэг тавьж, үйл ажиллагааг нь чиглүүлнэ.

Ар талын дарга дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Ар талыг бүх талаар бэлтгэх.
- Ар талын салбаруудыг дэлгэн байрлуулах, бий болсон цагийн байдлын өөрчлөлт, заставуудын гүйцэтгэж байгаа үүрэгтэй уялдуулан өөр районд шилжүүлэн байрлуулах.
- Материал хэрэгслийн тээвэрлэлтийг зохион байгуулах.
- Авто тээврийн салбаруудыг үр бүтээлтэй ашиглах.
- Тээвэрлэлт татан гаргалтын замыг сонгон авах, бэлтгэх, ашиглах.
- Захирагдсан албадын материалын хангалтыг удирдан зохион байгуулах.

Ар талын дарга үүргээ судлаж, цагийн байдлыг үнэлэх явцдаа өөртөө захирагдсан албадын дарга нар, ар талын салбаруудын захирагч нарт **урьдчилсан захирамж** өгдөг.

Урьдчилсан захирамжид. Материал хэрэгслийн нөөцийг байгуулах, ар талын техник хэрэгслүүдэд техникийн үйлчилгээ, засварын ажлыг хийж гүйцэтгэх, ар талын салбаруудыг дэлгэн байрлуулах газар орон дээр ар талын тагнуулыг зохион байгуулж явуулах, ар талын харуул, хамгаалалтыг зохион байгуулах болон бусад яаралтай хийж гүйцэтгэх ажлыг зааж өгнө.

Онцгой нөхцөл байдлын үед хилийн отрядын ар талын хангалтыг зохион байгуулах ар талын даргын шийдвэрт дараах асуудлууд тусгагдана¹.

Онцгой нөхцөл байдлын үед ар талын хангалтыг зохион байгуулах үндсэн баримт бичиг нь ар талын хангалтыг зохион байгуулах төлөвлөгөө юм. Цэргийн ар талд тавигдах нэн чухал шаардлагын нэг бол ар талын анги, салбаруудыг найдвартай , уян хатан, хатуу чанд удирдах явдал юм.

Бүх төрлийн холбоог тасалдуулахын тулд төрөл бүрийн идэвхитэй саатлыг бий болгож өргөнөөр хэрэглэх болсонтой холбогдуулан ар талын удирдлага найдвартай байх шаардлага тасралтгүй өндөржиж байгааг анхаарах хэрэгтэй. Онцгой байдлын үеийн хилийн отрядын ар талын хангалт, удирдлагын найдвартай үндэс бол ар талын анги, салбаруудын бие бүрэлдэхүүнийг тайван цагт сурган дадлагажуулах явдал юм.

¹ Хич хамгаалалтын дурмууд. 2006